



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/233

Булган сум

**Булган сумын 4 дүгээр цэцэрлэгийн барилга
хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалт, “Эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай” 2024 оны 671, 2025 оны 128 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Булган аймгийн Булган сумын 4 дүгээр цэцэрлэгийн 280 хүүхдийн 4,657,143,302 (дөрвөн тэрбум зургаан зуун тавин долоон сая нэг зуун дөчин гурван мянга гурван зуун хоёр) төгрөгийн цэцэрлэгийн барилга хүлээн авах, бүртгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
Т.Баттулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)
Ц.Цолмонбаатар (Боловсролын газрын дарга)
Д.Бямбажаргал (Булган сумын Засаг дарга)
Ж.Эрдэнэбулган (Онцгой байдлын газрын Гал
түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад)
Г.Ганзориг (Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын
хэлтсийн дарга)
П.Ариунаа (Булган сумын 4 дүгээр Цэцэрлэгийн эрхлэгч)
Нарийн бичгийн дарга: Д.Уламбаяр (Орон нутгийн өмчийн газрын Өмчийн
бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн)

2. Барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулсан хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт холбогдох баримтыг баталгаажуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (О.Ундрах)-д даалгасугай.

3.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу эзэмшигч байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим системд"-д бүртгэхийг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР